

## **ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 21-т “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн ... зохицуулалтыг бүхэлд нь боловсронгуй болгох,”-оор зааж шинэчлэн найруулахаар, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.12-д “...хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль, эрх зүйн орчинг сайжруулах”-аар тус тус шийдвэрлэсэн байна.

Монгол Улсын Их хурлын эдгээр шийдвэрүүд нь Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болсон.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх явцад учирч байгаа саад бэрхшээлийг арилгах, хуулийн доторх зөрчилтэй заалтууд болон бусад хуулиудтай зөрчилдөж байгаа заалтуудыг шинэчлэн найруулах, холбогдох судалгааны дүн, гадаад орнуудын хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль, эрх зүйн зохицуулалтын туршлага зэрэгт үндэслэн Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулав.

1.Хуулийн төсөл нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах харилцааг зохицуулах бөгөөд одоо хэрэгжиж байгаа хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр боловсруулав. Хуулийн төсөл 6 бүлэг 23 зүйлтэй бөгөөд бүлэг тус бүрт дараах харилцааг зохицуулахаар тусгасан. Үүнд:

Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл.

Тус бүлэгт Хуулийн зорилт, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль тогтоомж, Хуулийн нэр томьёо, Хэрэглэгчийн эрхийг хамгаалахад баримтлах зарчим зэрэг харилцаануудыг зохицуулахаар тусгав. Хуулийн зорилт гэсэн 1 дүгээр зүйлд “... хэрэглэгчийн эрхийг хамгаалах байгууллагын эрх зүйн байдал түүнтэй” холбоотой харилцааг зохицуулахаар нэмж тусгасан. Тус хуулинд 2008 онд нэмэлт өөрчлөлт оруулж хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт шилжүүлсэн ч тус байгууллагын бүрэн эрхийг зохицуулаагүйгээс хуулийг хэрэгжүүлэх ажил бүрхэг болсон. Иймд хуулийн хэрэгжилтийг хангах байгууллагын эрх зүйн байдлыг чиг үүрэгтэй нь уялдуулан тусгасан. Мөн тус бүлгийн 3 дугаар зүйлд “бараа бүтээгдэхүүн”, “аж ахуй эрхлэгч”, “цахим худалдаа” гэсэн нэр томьёонуудыг тодорхойлж тусгасан.

Хоёрдугаар бүлэг. Хэрэглэгчийн эрх.

Тус бүлэгт хэрэглэгчийн чанар, аюулгүй байдлыг хангасан бараа хэрэглэх, ажил, үйлчилгээгээр хангуулах эрх, үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн буруугаас

учирсан гэм хорыг арилгуулах, нөхөн төлүүлэх эрх, барааны талаар мэдээлэл авах эрх, төрийн эрх бүхий байгууллагаар хамгаалуулах эрхүүдийг тус тус зохицуулсан.

Гуравдугаар бүлэг. Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн үүрэг.

Тус бүлэгт үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн үүрэг, бараанд баталгаат хугацаа тогтоох, засвар хийх, техникийн үйлчилгээ үзүүлэх, бараа, ажил, үйлчилгээний доголдлыг арилгах үүргүүд болон цахим худалдаа, үйлчилгээ эрхлэгчдэд тавигдах шаардлагыг тусгасан. Тус хуулийн төсөлд цахим худалдаа, үйлчилгээн дэх хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудлыг шинээр тусгасан.

Дөрөвдүгээр бүлэг. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах талаар төрийн байгууллагын бүрэн эрх.

Тус бүлэгт хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудлаар Засгийн газрын бүрэн эрх, Яам, агентлаг болон Засгийн газраас байгуулдаг төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх, бүх шатны Засаг даргын бүрэн эрх, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, түүний бүрэн эрхийг тусгасан.

Тавдугаар бүлэг. Нутгийн өөрөө удирдах байгууллага болон төрийн бус байгууллагын хэрэглэгчийн эрхийг хамгаалах талаарх бүрэн эрх.

Тус бүлэгт Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын бүрэн эрх, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн бус байгууллагын чиг үүргийг тусгасан.

Зургаадугаар бүлэг. Бусад асуудал.

Тус бүлэгт хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын асуудлыг тусгасан. Зөрчил гаргасан этгээдэд Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд зааснаар хариуцлага хүлээлгэхээр заасан.

2.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах харилцааг анх 1991 онд баталсан Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулиар зохицуулж ирсэн бөгөөд үүнээс хойш 1996, 1997, 2002 онуудад нэмэлт өөрчлөлт оруулж, 2003 онд шинэчилсэн найруулгаар баталж, 2008, 2015 онд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

3.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахтай холбогдуулан Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу холбогдох үе шатны ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааг хийж хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулан батлуулсан. Батлагдсан үзэл баримтлалын дагуу Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, хуулийн төслийн үр нөлөөллийн үнэлгээг тус тус хийж гүйцэтгэсэн.

4. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж 2018 оны 5 сараас 8 сарын хооронд бүх Яамд, Аймаг, нийслэл, дүүрэгт ажилладаг Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хяналт тавих орон тооны бус салбар зөвлөлүүдээс нэг бүрчлэн албан бичгээр санал авсан. Мөн 2018 оны 10 дугаар сард Төрийн ордонд зохион

байгуулсан “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах улсын зөвлөгөөн”-өөр тусгай хөтөлбөрийн дагуу хэлэлцүүлсэн. Тус зөвлөгөөнд бүх аймаг, нийслэл, дүүргийн төр захиргааны байгууллагууд, төрийн бус байгууллагууд болон аж ахуйн нэгж байгууллагуудын 600 гаруй төлөөлөгчид оролцож өргөн хэлэлцүүлэг болсон. 2019 оны 1 дүгээр сарын 25 –нд Хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд, МҮХАҮТ, МҮЭХ зэрэг байгууллагуудын төлөөллүүдийн бүрэлдэхүүнтэй хэлэлцүүлэг явуулсан. Мөн цахим худалдаатай холбоотой шинээр тусгасан зохицуулалттай холбогдуулан мэргэжлийн байгууллагуудаас албан бичгээр санал авсан.

Дээрх ирүүлсэн саналууд болон хэлэлцүүлэг, зөвлөгөөний үеэр гарсан саналуудыг хуулийн төсөлд тусгасан.

5. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахад ХБНГУ, Европын холбоо, БНХАУ, Австрали улсуудын хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалтуудаас туршлага судалсан. Эдгээр орнуудын хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль эрх зүйн баримт бичгүүдийг орчуулж судалсан болно.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР